



УНГАР ДАХЬ МОНГОЛЫН ӨВ СОЁЛЫН ДУРСГАЛУУД

Ерөнхий редактор
БИРТАЛАН АГНЕШ

Төслийн удирдагч
САМПИЛДОНДОВ ЧУЛУУН

TREASURES OF MONGOLIAN CULTURAL AND HISTORICAL HERITAGE IN HUNGARY

Edited by ÁGNES BIRTALAN

Project leader
SAMPILDONDOW CHULUUN



Улаанбаатар – Будапешт
Ulaanbaatar – Budapest
IAMS – ELTE
2020

CONTENT

Introduction of the Series (<i>Sampildondow Chuluun</i>)	6
Greetings (<i>Erdenetsogt Sonintogos</i>)	7
Magyars and Mongols (<i>Ágnes Birtalan</i>)	8
■ Hungarians' Interest in Mongolian History, Language and Culture	11
Brief Survey of Mongolian Studies in Hungary (<i>Ágnes Birtalan</i>)	13
■ The Department of Mongolian and Inner Asian Studies, Eötvös Loránd University (ELTE) Budapest	15
■ Philology and Fieldwork	18
The Mongolian Manuscripts and Blockprints in the Oriental Collection of the Library of the Hungarian Academy of Sciences (<i>Ágnes Birtalan</i>)	21
■ A Brief History of the Oriental Collection	21
■ The Mongolian and Manchu Collection	23
■ The Tibetan Manuscripts and Blockprints from Mongolia	25
Specimina of Mongolian Manuscripts and Blockprints in the Oriental Collection (<i>Attila Rákos</i>)	26
Samples of Tibetan Manuscripts and Blockprints from Mongolia (<i>Gergely Orosz</i>)	62
The Museum of Ethnography (<i>Gábor Wilhelm</i>)	68
Vilmos Diószegi's Shamanic Objects (<i>Gábor Wilhelm</i>)	69
■ Photos	88
The Hans Leder Collection in the Museum of Ethnography (<i>Adrienn Gecse</i>)	99
Thangkas, Ritual Cards, Votive Plaques, Stupas, Cam Figures and other Ritual Objets (<i>Krisztina Teleki</i>)	101
■ Hanging Scrolls (<i>Thangka</i>)	101
■ Ritual Cards (<i>Tsakli</i>)	126
■ Votive Plaques (<i>Tshatsha</i>)	135
■ Cam Figures	140
■ Other Objects	146
Statues and Amulet (Charm) Boxes (<i>Adrienn Gecse</i>)	153
■ Statues	153
■ Amulet boxes	168
The Mongolian Collection of the Ferenc Hopp Museum of Asiatic Arts (<i>Judit Vinkovics</i>)	176
Buddhist Artefacts (<i>Judit Vinkovics</i>)	178
Special Collection of Ordos Bronze Objects (<i>Györgyi Fajcsák</i>)	215
The Hungarian National Museum (<i>Ágnes Birtalan</i>)	218
The Andor Radnóti Collection of the Hungarian National Museum (<i>S. Chuluun</i>)	219
Abbreviations	242
Bibliography	243

УГСААТНЫ ЗҮЙН МУЗЕЙН ХАНС ЛЕДЕРИЙН ЦУГЛУУЛГА

Гече Адриенн

Ханс Ледер 1843 онд тухайн үед Австри-Унгарын эзэнт улсын хэсэг байсан, одоогийн Бүгд Найрамдах Чех Улсын Опава хотод мэндэлжээ. Намтраас нь харахад тэрээр шавьж судлалыг ихээхэн сонирхож амьдралынхаа талыг шинжлэх ухааны уг салбарт зориулжээ. Ханс Ледер гайхалтай цуглуулагч байсан бөгөөд угсаатан судлал, Монгол орныг сонирхох хүртэлээ шавьж судлалыг хамаг цагаа зориулж байв. 1905 он гэхэд голдуу бурханы шашны зан үйлийн эд хэрэглэл бүхий цуглуулгатай болжээ. 1892 онд анх Монгол руу аялаад түүнээс хойш гурван ч удаа очихдоо самбаа, санаачлага, асар их хүчин чармайлтаар угсаатны эд өлгийн зүйлс цуглуулжээ. Ихэнх нь хүмүүсийн хувийн эдэлж хэрэглэж байсан зүйлс гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тэдгээр эд өлгийн зүйлсийг айлаас, суварга, тахилгатай газраас авчээ. Өнөө бидний үед цуглуулгын энэ арга ёс суртахууны хувьд байж боломгүй мэт санагдах авч цуглуулагчдын нүдээр бол түүний цуглуулганд онцгой үнэ цэнэ нэмж, магадгүй жинхэнэ эх болохыг харуулах юм. 4500 гаруй эд өлгийн зүйлтэй түүний цуглуулга бүхэлдээ давтагдашгүй, хосгүй цуглуулга болох нь маргаангүй. 1930-аад оны сүүлийн хэдхэн жилд хэдэн арван мянган хүн алагдаж, лам нарыг цаазалж, бурханы шашны сүм хийдүүд, ном судрууд, эд өлгийн зүйлс, шүтээнийг устгасан хэлмэгдүүлэлт хэдэн арван жил үргэлжилсэн гэдгийг мартаж болохгүй. Ханс Ледер эдгээр эд өлгийн зүйлсийг цуглуулснаараа өнөө үгүй болсон байж болох зүйлсийг хамгаалж үлдэж чадсан юм. Ледерийн цуглуулга бурханы шашны сүсэгтнүүд амьдралдаа, өдөр тутамдаа хийдэг зан үйлийн талаар нарийн тодорхой мэдээлэл өгсөөр ирсэн билээ. Тэрээр 1882–1905 оны хооронд цуглуулгаа хийсэн бөгөөд Европын хэд хэдэн угсаатны зүйн музейд: Венийн Велт музей, Штутгартын Линденийн нэрэмжит музей, Хэйдэлбэрг хотын Угсаатны зүйн музей, Лейпциг хотын Угсаатны зүйн музей, Ганбург хотын Угсаатны зүйн музей, Будапештийн Угсаатны зүйн музей, Прагийн Угсаатны зүйн музейд түүний цуглуулгын эд зүйлс хадгалагдаж байдаг.

THE HANS LEDER COLLECTION IN THE MUSEUM OF ETHNOGRAPHY

Adrienn Gecse

Hans Leder was born in 1843 in Javornik, then part of the Austro-Hungarian Monarchy, today Opava in the Czech Republic. According to his contemporaries, his greatest passion was entomology, and he dedicated the first part of his life to this science. He was a significant collector and participated in entomological activities, up until his attention turned to ethnography and Mongolia. By 1905, he became a renowned collector of mainly Buddhist ritual artefacts. He first travelled to Mongolia in 1892, followed by three more trips to the country, all focused on collecting ethnographic items in ways that required resilience, creativity and outstanding dedication. It is important to note that most of the objects came from people's personal use. It means that they belonged to the altars of yurts, or they had been taken from stupas and other sacred places. In our days this method of collection may seem morally unacceptable for some, but in the eyes of the collector, this added unique value, perhaps some kind of authenticity to his findings. Indisputably, with over 4,500 items, the size of his collection as a whole is exceptional. We must not forget that in the late 1930s, within a very brief period, tens of thousands of people were killed, lamas executed, Buddhist monasteries, manuscripts, artefacts and relics destroyed, and the repression continued for decades. With his work, he managed to preserve objects that otherwise would have been lost by now. The Leder collection gives a deep insight into the lives and daily rituals of Buddhist devotees, showing us a slice of Buddhist traditions that had been eliminated by the purges for decades to come. He accumulated the items between 1882 and 1905, which are scattered now over several ethnographic museums in Europe: Weltmuseum Wien, Linden-Museum Stuttgart, Völkerkundemuseum der J. & E. von Portheim Stiftung Heidelberg, Grassimuseum für Völkerkunde zu Leipzig, Völkerkundemuseum Hamburg, Néprajzi Múzeum Budapest and Náprstek Museum Prague.

Until today, the Leder collections have been described in the greatest of detail by the publication entitled *The Mongolian Collections: Retracting Hans Leder*, edited by Maria-Katharina Lang and

Өнөөдрийг хүртэл Ледерийн цуглуулгын талаар Мариа-Катарина Ланг, Штефан Бауер нарын эмхэтгэсэн *Монголын цуглуулгууд: Ханс Ледерийн цуглуулга* бүтээлд хамгийн дэлгэрэнгүй тайлбарласан бий. Энэхүү цуглуулгын тухай танилцуулганд бид түүхэн баримт, бусад мэдээлэлд тулгарлаа. Бид Будапешт хотын Угсаатны зүйн музейд хадгалагдаж буй цуглуулгын тухай илүү нарийн дэлгэрэнгүй мэдээлэл өгөх одоогийн төслөө улам өргөжүүлэхээр ажиллаж байна. Манай музей анх 1904 онд, дараа нь 1905 онд хоёр удаа цуглуулагчдаас эд зүйлс худалдан авсан байдаг. Музейн бүртгэлээс харахад Ханс Ледерийн нэртэй холбоотой 600 орчим эд зүйлс байгаагаас тал орчмыг монголоос авчирсан байна. Тухайлан энэ цуглуулгад хамаарах зүйлсийг шинээр данслаагүй боловч музейд дараах зүйлс байдгийг 1963 онд эдгээр материалыг судалж байсан Лумир Йислын тэмдэглэлээс мэдэж болно. Үүнд: 207 цац, хоёр баримал, 32 шавар суварга, нэг хүрэл суварга, цамын 22 модон дүрс, 50 гаруй жижиг хүрэл баримал, хэд хэдэн бар, цаасан шуумал, дөрвөн хүрд, шатрын 89 мод, гурван очир, нэг титэм, хоёр гавлан аяга, жижиг хэмжээтэй 219 зураг буюу загал зураг, олон шүтээн зураг, модон барын зураг болон янз бүрийн зургууд байна. (Lang-Bauer 2013:9–24). Ханс Ледерийн энэ гайхамшигтай өвөөс бид шүтээн зураг, зураг, цац, цамын дүр, шатрын мод, баримал, гуу, бусад шүтээн нийт 60 зүйлийг танилцуулах юм.

Stefan Bauer. In regard to the historical facts and other data that we share in present introduction of the collection, we rely on this publication. This is the work we aim to further expand in this current project by giving even more detail about the collection housed in the Museum of Ethnography in Budapest. The Museum purchased items twice from the collector, first in 1904, then in 1905. According to the Museum register, there are nearly 600 items that we can link to the name of Hans Leder, and around half of these are from Mongolia. We do not have an up-to-date inventory of the objects that belong to this particular collection, but we do know from the notes of Lumír Jisl, who studied the material in 1963, that the museum then held 207 *tshatshas*, two grand reliefs, 32 clay and one bronze stupas, 22 wooden figures of Tsam dancers, more than 50 small bronze sculptures, several printing plates and papier-mâché figures, four prayer wheels, 89 chess figures, three *vajra*, one "titim" crown, two skull cups, 219 miniature paintings or *tsaklis* and many *thangkas*, woodprints and various paintings (Lang-Bauer 2013:9–24). From this remarkable legacy of Hans Leder, we will introduce hanging scrolls, ritual cards, votive plaques, Tsam and chess figures, statues, amulet boxes and other relics, altogether 60 objects.



№ 59734

VIII Богд Жавзандамба хутагт

Фото зураг, уран зураг хосолсон зураг бол XVII зуунд Гэлүгвагийн урсгалыг Халх Монголд дэлгэрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн алдартай хувилгаан Өндөр гэгээн Занабазар (1635–1723)-ын хойд дүр VIII Богд Жавзундамба Агваанлуvsанчойжинямданзанванчүг (1869–1924) хутагтын хөрөг юм. VIII Богд Жавзундамба хутагт төвөд хүн байсан бөгөөд 1911 оноос 1921 оныг хүртэл Тусгаар тогтносон Монгол улсын шашин төрийг хослон баригч хаан, Богд хаан хэмээн өргөмжлөгджээ. Энэ зураг тэдгээр оноос өмнөх юм. Богд хаан сэнтийдээ завилсан байна. Тэрээр монгол дээл, монгол маягийн малгай өмсчээ. Баруун мутартаа лянхуа цэцгийн иш барьж, зүүн мутраа залбирах мэт зангажээ. Дамар, цөгц, номын хүрд, өргөлийн зүйлтэй гавлан аяга зэрэг зан үйлийн хэрэгсэл өмнө нь байна. Зэсэн дээр гагнаж тогтоосон байна.

Нэр: *Наймдугаар Богд Жавзундамба хутагт*; мон. *Naimdūyār boyda gegen, Jībjudamba qutuγtu*; тө. *Ngag dbang blo bzang chos kyi nyi ma bstan 'dzin dbang phyug, Khal kha rje btsun dam pa sku phreng brgyad pa*

Цаг үе: XX зууны эхэн

Ерөнхий шинж: 11.5×8 см, загал зураг, фото зураг; гууль, цаас, зурсан, даавуун дээр будсан

Байршил: Угсаатны зүйн музей, Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 59734

Цуглуулгад ирсэн: 1905 оны 12 дугаар сарын 5

Мөн үзэх: collection.neprajz.hu; moncol.net

Portrait of the Eighth Bogd Jebcündamba Xutagt

This collage of photography and painting shows the Eighth Bogd Jebcündamba xutagt, Agwaanluvsančojjinyamdanjanwančüg (1869–1924), a reincarnation of Öndör Gegeen Janabajar (1635–1723), the eminent monk who had a major role in spreading the Geluk teaching in the area of the Khalkha Mongols in the 17th century. His reincarnation, the Eighth Bogd Jebcündamba xutagt was with Tibetan origin and became the theocratic king of the sovereign Mongolia from 1911 to 1921 bearing the title “Bogd хаан” (‘holy king’). This image is earlier and shows him sitting in a meditative posture on cushions and a lion throne. He wears a Mongolian shirt and a kind of Mongolian hat. He shows the gesture of bestowing fearlessness and holds the stem of a lotus flower with his right hand. His left hand displays the gesture of meditation. Ritual objects are placed in front of him including a *damaru* drum, a butter lamp, the wheel of Dharma, and a skull-cup with inner offerings. The image is soldered to a piece of brass.

Name: *Khal. Naimdugaar Bogd Jawjandamba xutagt; Mong. Naimdūyār boyda gegen, Jībjudamba qutuγtu; Tib. Ngag dbang blo bzang chos kyi nyi ma bstan 'dzin dbang phyug, Khal kha rje btsun dam pa sku phreng brgyad pa*

Period: beginning of the 20th century

Physical features: 11.5×8 cm, *tsakli*, photograph; brass, paper, painted, pigment on cotton

Location: Museum of Ethnography, Hans Leder Collection (Budapest)

Inventory number: 59734

Acquisition: collected on 5 December 1905

See also: collection.neprajz.hu; moncol.net

БАРИМАЛ, ГУУ

Гече Адриэнн

БАРИМАЛ

Баримал шашны үйл ажиллагаанд гол үүрэгтэй тул Монголд ихээхэн анхаардаг. Баримал бол бурханы шашны уламжлал, эгэл ардын өдөр тутмын шашны үйлд голлох үүрэгтэй. Шүтээний газар, сүм хийд, гэр ер хаана ч залсан байлаа маш ихээр хүндлэн, арчилж хамгаалдаг. Хүрэл, чулуу, мод, шавар, цаас бүр тосоор хүртэл хийсэн байдаг. Нарийн хийцтэй урлагийн бүтээл байхаас эхлээд зохилдоо, харьцаа алдсан баримлууд ч ач холбогдлоо алддаггүй. Бурхан, бодьсатва, шашны өндөр дээд хүмүүсийг баримлаар төлөөлүүлэн лам, сүсэгтнүүд мөргөл үйлдэх, бясалгалдаа түүнд төвлөрдөг. Социалист нийгмийн үеэс өмнө тийм баримлуудыг захиалгаар голдуу хийдэг байжээ. Чинээлэг хүмүүс бурханы шашны олон дүрүүдийг тусгайлан захиалж хийлгэдэг байв. Үнэтэй материалаар хийлгэх нь өөрийн болоод хамаг амьтны тусын тулд буян хурааж байгаа хэрэг бөгөөд энэ нь бурханы шашны ёс зүйн үндсэн зарчим юм. Буян хураана гэдэг нь эрүүл саруул, элбэг баян байх, гэгээрэлд хүрэх зам мөрт туслах хүч юм. Энэ санаа нь уран зураач, дархчуудад өгөөжтэй нь тодорхой. Тэд хувь нэмрээ оруулна мөн мэргэжлийн чадвар нь өсөж дэвжинэ. Хувь хүн, сүм хийдүүд, лам нар захиалж, бүтээлгэж байсан. Бичиж тэмдэглэсэн материал ховор байдгаас XVII зууны зураач, шашны тэргүүн, алдарт Занабазар зэрэг нэртэй зарим урлаачдаас бусад урлаачдын талаар мэдээлэл бага, тогтооход хэцүү билээ. Бурханы шашны чинадын мөн чанараас үүдэн бүтээл нь урлаачаасаа илүү чухал байна. Нууцлаг, хүмүүний ертөнцийн бус зүйлийг чинадын гэж нэрлэж байгаа юм. Бурхан урлаачид бүтээл бүрийг онцгой хийхийн тулд хэн бүхний хүрч чаддаггүй тэрхүү ертөнцтэй холбогдоно. Энэ бүлэгт Мариа Катарина Ланг, Штефан Бауэр нарын каталоги, номонд (Gecse 2016) ороогүй эд зүйлсэд анхаарал хандуулав.

STATUES AND AMULET (CHARM) BOXES

Adrienn Gecse

STATUES

Statues, due to their role in religious ceremonies, receive particular attention in Mongolia. They are central to Buddhist traditions and the daily religious practices of ordinary people. They are highly respected and carefully looked after whether they are placed in a shrine, a temple or a yurt. In their production, bronze, stone, wood, clay, paper and even butter are used. They are not only highly aesthetic in most cases – even the less refined pieces strain after harmonious features and proportions –, but they achieve practical function as well. They can serve as a kind of guidance during meditation, when the practitioner focuses on the personality represented by the statue of the given Buddha, Bodhisattva, god, goddess, or a high-ranking religious leader. Prior to the period of Socialism, statues were mostly made to orders, when wealthy people specifically ordered the imagery of various Buddhist personalities. Through the use of the most precious materials, they hoped to gain merit for themselves or all living beings, which is a fundamental concept to Buddhist ethics. Gaining merit is a protective force that brings good health, financial success, and helps the individual’s path towards enlightenment. This practice proved to be beneficial for artists and artisans too, as it contributed to and shaped their professional development. An order could be made by a single person or a monastery and its monks. In lack of written sources, we do not know much about the makers or artists, it is very difficult to identify most of them, except the most well-known representatives of the art, like Dzanabadzar, the famous, 17th century artist and spiritual leader. In Buddhism, due to its sacred nature, the artwork itself is more important than its maker, despite the mysterious atmosphere that surrounds them, as they call the sacred, something that is beyond the mundane world, into daily life. Statue makers are connected to a world that is unreachable by most, creating something unique and elusive with each of their work. In this section we focus on objects that have not been included in the work of Maria-Katharina Lang and Stefan Bauer, nor were they previously described in other catalogues or publications (Gecse 2016).

Зөөлөн эгшигт (Манзушир)

Мэргэн билэг ухааны бодьсадва, Балба орныг ивээгч Манзушир бурханыг залуу гоолиг биетэй, лянхуа цэцгэн сэнтийд завилан суугаагаар дүрсэлжээ. Бурханы шашны утга зохиолд важраасана *vajrāsana* (сөхөрч суух) гэж нэрлэсэн байх боловч барууныхан Хинду нэрээр нь илүү мэддэг. Лянхуа цэцэг ургаж буй орчноосоо үл хамааран толбогүй цэврээрээ байдаг тул цэвэр ариун, төгс төгөлдөрийг бэлгэддэг. Уг цэцгийг Төв Азийн төдийгүй дэлхийн олон оронд ариун дагшинь бэлгэдэл гэж үздэг. Манзушир бурхан намжур өмссөн байх ч хөлийн үзүүр хэсэг харагдана. Баруун хөлөө зүүн гуян дээрээ тавьсан нь харагдах бөгөөд үүнийг очир завилгаа буюу важраасана *vajrasana*, важрапарянка *vajraparyanka* (Tib. *rdo rje skyil krung*) байрлал гэж нэрлэдэг (Beer 1996:158) Баруун мутраа өргөж, зүүн мутар тайлбарлах, номлох байрлалд байна (Beer 1996:156). Ээмэг, хүзүүний зүүлт, титэм зүүжээ. Энэхүү хүрэл баримлыг урлаач гоо үзэсгэлэн гэхээсээ утга агуулгыг чухалчилсан болов уу. Гэвч баримлын хэм, галбир төгс зохицолтой, гүн сүсэглэлд татаж чадах мэт. Ийм энгийн байгаа нь Ханс Ледер эд өлгийн зүйлийг цуглуулахдаа айлаас худалдаж авах, тухайн орны олон газрын сүм хийдийн шүтээнээс заримдаа нууцаар авах зэрэг газар дээрээ шууд авч байсантай холбоотой (Lang-Bauer 2013:15). Тухайн үед уг жижиг баримал, эзнийх нь санхүүгийн хэрэгцээнд дүйж байсан бололтой.

Нэр: *Манзушир, Манзашир, Манзушир*; мон. *Manjusiri, Manjasiri*; тө. *‘Jam dpal*; скр. *Mañjuśrī*

Гарал: Монгол, XIX зуун

Ерөнхий шинж: 13×7×6 см; хүрэл; цутгамал

Байршил: Угсаатны зүйн музейн Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 55843

Цуглуулсан: Төвдөөс, 1904 оны 12 дугаар сарын 20

Мөн үзэх: moncol.net; collection.neprajz.hu

Mañjuśrī

Mañjuśrī, the bodhisattva of transcendental wisdom and a patron of Nepal, is depicted as a slender youth, sitting on a lotus throne in a lotus posture. The Buddhist literature refers to it as *vajrāsana*, but the West tends to use its more widely known Hindu name. The lotus, which symbolizes absolute purity and perfection, stays unstained regardless of the environment it grows from, and it is considered a sacred symbol in many parts of the world, not only in Central Asia. The bodhisattva wears a skirt but the outlines of his feet are visible, and we can see his right foot forward over the left thigh, which we call the *vajrāsana* or *vajraparyanka* (Tib. *rdo rje skyil krung*) posture (Beer 1996:158). His right hand is raised high, while his left hand is in the so called *virtaka mudrā* of reasoning or explanation of the teachings (Beer 1996:156). He also wears earrings, necklaces and a crown. The workmanship of the bronze statue as a whole is almost stylized, as if function were more important for its maker than beauty. And still, due to its delicate iconometry, the figure emits perfect harmony and invites devotees for deep meditation. We can easily attribute this simplicity to the fact that Hans Leder purchased artefacts of his collection directly from the yurts, and at times he secretly took them from sacred shrines at various places of the country (Lang-Bauer 2013:15). Most probably, at the time of making, the monetary value and hence the elaboration of this small piece had been equal to the financial situation of its original owner.

Name: Khal. *Manjšir, Manjašir, Manjuširi*; Mong. *Manjusiri, Manjasiri*; Tib. *‘Jam dpal*; Skr. *Mañjuśrī*

Origin: Mongolia, 19th century

Physical features: 13×7×6 cm; bronze; cast

Location: Museum of Ethnography, Hans Leder Collection (Budapest)

Inventory number: 55843

Acquisition: collected in Tibet, 20 December 1904

See also: moncol.net; collection.neprajz.hu

Бакула найдан

Шагжтүв бурханы арван зургаан тэргүүлэх шавийн нэг нь Бакула (Tib. *gnas brtan ba ku la*) юм. Тэрээр Бурхан багштай уулзаад өтөл насандаа бурханы шашинд орж машид богино хугацаанд архадын дайтад хүрчээ. Түүнийг ихэвчлэн эд баялгийн бэлгэдэл үхэр хулгана барьснаар дүрсэлдэг бөгөөд энэ баримал ч мөн адил ажээ. “Бурханы шашны сургаалиудыг бүгдийг ойлгоход шаардагдах-таван мэдрэхүйг сайжруулж, зургаан билиг барамидыг олж авах, хоосон чанарыг ойлгох, хайраа харуулах чадвар, амьтай бүхнийг энэрэл нигүүлсэх хүчтэй.” (Bakula. In: *Chinese Buddhist Encyclopedia* (“Хятадын бурханы шашны нэвтэрхий толь”-д)). Гуулиар цутгасан энэ баримлын суурин дээр ургамлын дүрс байх агаад энэтхэгт эрт үеэс модыг ариун гэж үздэг байжээ (Beer 1996:48). Бакула архад лам хуврагууд,

Arhat Bakula

Bakula, the Elder (Tib. *gnas brtan ba ku la*), is one of the sixteen principal students of Buddha Śākyamuni. He embraced Buddhism in old age after meeting the Tathagata Śākyamuni and quickly attained the level of an arhat. He is often depicted with the wealth-bestowing mongoose as in case of this statue too, “which has the power to grant the requisites for understanding all of the Buddha’s teachings – refinement of the five senses, the ability to attain the six paramitas, understand shunyata and manifest love and compassion for all beings” (Bakula. In: *Chinese Buddhist Encyclopedia*). The throne of this cast brass statue is engraved with the signs of vegetation, as trees had been endowed with sacred qualities already in ancient India (Beer 1996:48). The Arhat wears a robe, the traditional attribute of lamas or high rank dignitaries.

ихэс дээдсийн уламжлалт шинж тэмдэг болсон урт өмсгөл өмсжээ.

Нэр: *Бакула*; мон. *Bakkula*; тө. *Ba ku la*; скр. Skr. *Bakula*

Гарал: Монгол, XIX зуун

Ерөнхий шинж: 8.5×7×5 см; гууль; цутгамал

Байршил: Угсаатны зүйн музейн Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 55821

Цуглуулсан: Төвдөөс, 1904 оны 12 дугаар сарын 20

Мөн үзэх: moncol.net; collection.neprajz.hu

Name: Khal. *Baxulaa*; Mong. *Bakkula*; Tib. *Ba ku la*; Skr. *Bakula*

Origin: Mongolia, 19th century

Physical features: 8.5×7×5 cm; brass; cast

Location: Museum of Ethnography, Hans Leder Collection (Budapest)

Inventory number: 55821

Acquisition: collected in Tibet, 20 December 1904

See also: moncol.net; collection.neprajz.hu



№ 55843

№ 55821



№ 55842

Цаглашгүй наст (Аюуш)

Мөнх насны бурхан Авид бурханы нэг дүр, Жанрайсэг бурханы оюун санааны эцэг гэгддэг Цаглашгүй наст (тө. *Tshe dpag med*) Очирт хөлгөний оройн дээд таван бурханы нэг, диваажингийн орноо орших бурхан юм (Stooke 1961:214) Цаглашгүй наст гарын алгыг зөрүүлж өвөр дээрээ тавин завилан сууна. Зүүн гарын алгыг баруун алганы доор тавьсан нь “арга ухаан буюу чадвар нь оюун билиг буюу хоосон чанарын тухай ойлголтоос үүдэлтэй”-г илэрхийлнэ (Beer 1996:154). Тэрээр бясалгалын төгс байрлалд байна. Ихэд чимэглэсэн титмээс гадна ээмэг, хүзүүний зүүлт, бугуйвч тэр байтугай бугалгандаа зүүлт зүүсэн нь бие болоод сэтгэлийг амирлуулан бясалгалын чинадад хүрэхэд туслалт юм. Цаглашгүй наст амгалан, бурханлаг төрхтэй (Bodhisattva & Bodhisattva Appearance. In: *Himalayan Art Resources*. (Бодьсадва, Бодьсадвагийн гадаад байдал. “Гималайн урлагийн бүтээлүүд”-д)) дүрслэгджээ.

Нэр: Цаглашгүй наст, Аюуш, Цэгмид, Цэвэгмэд;
мон. *ᠴайласи үгеи насун, Аюуси*; тө. *Tshe dpag med*; скр. *Amitāyus*

Гарал: Монгол, XIX зуун

Ерөнхий шинж: 14.5×9.5×7 см; гууль; цутгамал

Байршил: Угсаатны зүйн музейн Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 55842

Цуглуулсан: Төвөдөөс, 1904 оны 12 дугаар сарын 20

Мөн үзэх: moncol.net; collection.neprajz.hu

Amitāyus

Amitāyus (Tib. *Tshe dpag med*) – known as an aspect of Amitābha –, the Buddha of Eternal Life and the spiritual father of Avalokiteśvara, is one of the five cosmic Buddhas of Vajrayāna Buddhism, who lives in the Sukhāvati heaven (Stooke 1961:214). He is seated with his hands in his lap in the *dhyāna mudrā* of meditation. The left hand is placed below the right, symbolizing that “the accomplishment of method or skilful means has to arise from a direct understanding of wisdom or emptiness” (Beer 1996:154). We can see him seated in a perfect state of meditation. He wears a richly decorated crown as well as earrings, necklaces, bracelets and even bangles, all to help his devotees to reach the same meditative state through his aesthetic harmony and perfect proportions that calm body and mind alike. Amitāyus has a Bodhisattva appearance in contrast with Amitābha’s Buddha appearance, that is, he is depicted as a peaceful, god-like figure (Bodhisattva & Bodhisattva Appearance. In: *Himalayan Art Resources*.).

Name: Khal. *Caḡlaṣḡii nas, Ayuus, Cegmid, Cewegmed*;
Mong. *ᠴайласи үгеи насун, Аюуси*; Tib. *Tshe dpag med*;
Skr. *Amitāyus*

Origin: Mongolia, 19th century

Physical features: 14.5×9.5×7 cm; brass; cast

Location: Museum of Ethnography, Hans Leder Collection (Budapest)

Inventory number: 55842

Acquisition: collected in Tibet, 20 December 1904

See also: moncol.net; collection.neprajz.hu

Молон тойн

Шагжтүв бурханы анхны шавь нарын нэг Молон тойн лянхуа цэцэг дээр, баруун мутартаа дулдуй барин зогсоно. Дулдуй гэдэг нь үзүүртээ цагирагтай саваа юм. Урлаач юм уу захиалагчийн хүслээр дулдуйн үзүүрийн цагирагийн тоо янз бүр байна. Хутагт дөрвөн үнэнийг илэрхийлэх дөрвөн цагираг, арван хоёр шүтэн барилдлагыг илэрхийлэх арван хоёр цагираг байж болно. Лам хуврагууд дулдуйг амьтан айлгах, хандив өглөг цуглуулахаар хувраг ирж буйг мэдэгдэх зорилгоор амьдралдаа ашигладаг байжээ (Kieschnick 2013:113). Молон тойн даруухан эмжсэн хувраг хувцастай ажээ. Молон тойн сүсэгтний бодол, сэтгэлийг унших, өвчин зовуурь, баяр хөөрийг мэдрэх, түүний учир шалтгааныг тайлах зэрэг гайхамшигтай чадваруудтай байжээ (Bodhanada 1988). Түүний энэхүү ер бусын чадварууд энд түүнийг гурав дахь мэлмий буюу билгийн мэлмийтэй зурах шалтгаан буй заа.

Нэр: Молон тойн, *Moodgalawani*; мон. *Modyalavani, Molon toyin*; тө. *Mo 'u dgal mtshan*; скр. *Maudgalyāyana*

Гарал: Монгол, XIX зуун

Ерөнхий шинж: 9.5×4 см; гууль; цутгамал

Байршил: Угсаатны зүйн музейн Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 55850

Цуглуулсан: Төвөдөөс, 1904 оны 12 дугаар сарын 20

Мөн үзэх: moncol.net; collection.neprajz.hu

Maudgalyāyana

One of the historical Buddha’s main disciples, Maudgalyāyana is represented here standing on a lotus pedestal, holding a *khakkhara* in his right hand. A *khakkhara* is a ring staff with a central stick, to which rings are attached. The number of these rings vary, depending on the meaning the maker or the customer who ordered the piece would like to endow the statue with. Four rings can represent the Four Noble Truths, while twelve can symbolize the twelvefold chain of cause and effect. Considering the wondering life of monks, one possible use of the staff is especially practical. It can help to frighten off animals, and also alerts a donor to a monk’s presence, while he is collecting alms (Kieschnick 2013:113). He is dressed in a monk’s robe that is humbly decorated on its edges. Maudgalyāyana possessed extraordinary abilities, such as reading the minds and hearts of devotees, feeling their pain and pleasure, and he understood how they come to be as they were (Bodhanada 1988). These magic abilities might be the reason for being depicted here with a third eye or a wisdom eye.

Name: Khal. *Molon toin, Moodgalawani*; Mong. *Modyalavani, Molon toyin*; Tib. *Mo 'u dgal mtshan*; Skr. *Maudgalyāyana*

Origin: Mongolia, 19th century

Physical features: 9.5×4 cm; brass; cast

Location: Museum of Ethnography, Hans Leder Collection (Budapest)

Inventory number: 55850

Acquisition: collected in Tibet, 20 December 1904

See also: moncol.net; collection.neprajz.hu



№ 55850

Шарийбуу

Шарийбуу Молон тойны хамт Шагжтүв бурханы гол шавь байжээ. Олон эх сурвалжид түүнийг төрсөн тосгон Налакадаа нирваан болсон гэж тэмдэглэсэн байдаг (Prasad 1988:175–176). Палийн сударт түүнийг хоёр дахь бурхан гэж эрэмбэлжээ. Бурханы шашны бусад гэгээнтнүүдээс ялгаатай нь түүнийг бурханы шашны сүм хийдийн амьдралаар амьдарсан лам хувраг хүний төрхөөр дүрсэлжээ (Ray 1999:131–133). Шарийбуу лянхуа цэцэг дээр зогсоно. Баруун мутраа ном айлдах мэт авч, эрхий, дунд хуруугаа нийлүүлжээ (Beer 1996:156). Зүүн мутарт барьж буйг сайтар нягталваас судар бололтой. Чимэглэл багатай энгийн хуврагийн хувцас өмссөн байна. Уг бүтээл дэх билгийн мэлмий, урт чих нь гэгээрэл, энэрэл нигүүлслийг илэрхийлнэ. Гайхалтай сайхан урласан урлагийн бүтээл биш ч гуулины зөөлөн өнгө үзэмжтэй болгожээ.

Нэр: Шарын хөвүүн, Шаарийбуу; мон. *Šaribudai*; тө. *Shā ri'i bu*; санср. *Śāriputra*

Гарал: Монгол, XIX зуун

Ерөнхий шинж: 4×9.5 см; гууль; цутгамал

Байршил: Угсаатны зүйн музейн Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 55851

Цуглуулсан: Төвөдөөс, 1904 оны 12 дугаар сарын 20

Мөн үзэх: moncol.net; collection.neprajz.hu



№ 55851

Śāriputra

Śāriputra, together with Maudgalyāyana, was one of the chief disciples of the Buddha. According to various sources, he attained Parinirvāṇa in the same village where he was born, that is in Nālaka (Prasad 1988:175–176). In the Pāli Canon he is ranked as the second Buddha. Contrary to other Buddhist saints, he is depicted as a settled monk, who lives in accordance with classical monasticism and he embodies scholarly ideals (Ray 1999:131–133). Śāriputra is shown here standing on his lotus pedestal. His right hand is in the *varana mudrā* of reasoning or explanation of the teachings, formed with the thumb and the third finger touching (Beer 1996:156). Considering what he embodies, we can assume that the object he holds in his left hand is a *sūtra*. He wears a very simple monk's robe, imperceptibly decorated. The wisdom eye and long ears that appear on this representation, indicate enlightenment and compassion. This is not a greatly elaborated work of art, rather a simplified piece to the beauty of which the calming tone of brass significantly contributes.

Name: Khal. *Šariin xöwüün, Šariwu*; Mong. *Šaribudai*; Tib. *Shā ri'i bu*; Skr. *Śāriputra*

Origin: Mongolia, 19th century

Physical features: 4×9.5 cm; brass; cast

Location: Museum of Ethnography, Hans Leder Collection (Budapest)

Inventory number: 55851

Acquisition: collected in Tibet, 20 December 1904

See also: moncol.net; collection.neprajz.hu



№ 55853

Бисман тэнгэр

Хойд зүгийн тэнгэрийг сахигч, догшин дүрт дөрвөн махранзын нэг Бисман тэнгэр. Тэдгээр бурхад гэрт, сүм дуганд аль байгаа газраа сахин хамгаалдаг. Мөн ер бусын хүчтэй армиа удирдан бурханы шашныг сургаал номлолыг хамгаалдаг байна (Linrothe 1999:20). Бисман тэнгэрийг түгээмэл дүрсэлдэг жишгээр хуяг дуулгатай, хүнд гуталтай дүрсэлсэн байх ч зэр зэвсэгийн оронд зүүн мутарт нь хулгана, баруунд нь могой байх юм. Дугуй нүүртэй, өтгөн живэр, хууз сахалтай, хөмсөгтэй. Шулуудын тэргүүн тэрээр зөвхөн хамгаалагч бус бас өглөгийн эзэн ажээ. Уг баримал Ледерийн цуглуулга дахь бүх метал хийцтэй баримлуудын адил цутгамал агаад гар дээрх сааралдуу өнгөөс үзвэл хэсэг хэсгээр нь цутгаад дараа нь нэгтгэжээ.

Нэр: Сайтар сонсогчийн хөвүүн, Бисман тэнгэр, Намсрай, Намтай; мон. *Vayisiravani, Namtoyisarai*; тө. *rNam thos sras, rgyal chen rigs bzhi*; скр. *Vaiśravaṇa*

Гарал: Монгол, XIX зуун

Ерөнхий шинж: 5×11 см; гууль; цутгамал

Байршил: Угсаатны зүйн музейн Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 55853

Цуглуулсан: Төвөдөөс, 1904 оны 12 дугаар сарын 20

Мөн үзэх: moncol.net; collection.neprajz.hu



Vaiśravaṇa

Vaiśravaṇa, who guards the northern heaven, belongs to the group of *lokapālas* or the heavenly kings, who share a wrathful appearance. They serve to protect the place, be it a yurt or a temple. They are able to command an army of demonic powers to protect the Buddha's teachings (Linrothe 1999:20). Vaiśravaṇa, as most often happens, wears a full armour and strong boots in this representation, however, instead of weapons, he seems to hold a mongoose in his left hand and a snake in his right. He has a round face with emphasized moustache, beard and eyebrows. As a leader of the Yakṣas, he is not only a protector but a benefactor too. The statue, like all examined metal statues of the Leder collection, is made by casting, and the greyish parts on the arms show where individual pieces had been assembled by soldering.

Name: Khal. *Saitar sonsogčiin xöwüün, Bisman tenger, Namsrai, Namtai*; Mong. *Vayisiravani, Namtoyisarai*; Tib. *rNam thos sras, rgyal chen rigs bzhi*; Skr. *Vaiśravaṇa*

Origin: Mongolia, 19th century

Physical features: 5×11 cm; brass; cast

Location: Museum of Ethnography, Hans Leder Collection (Budapest)

Inventory number: 55853

Acquisition: collected in Tibet, 20 December 1904

See also: moncol.net; collection.neprajz.hu

Цаглашгүй гэрэл (Авид)

Цаглашгүй гэрэл, хязгааргүй оюун билгийн бурхан Авид бол энэ цагийн язгуурын таван бурханы нэг юм (Joyce 1922:3). Түүний сууж буй дүрийг хүрлээр бүтээсэн бөгөөд будаж, алтадсан байсан нь ажиглагдана. Биеийн харьцаа бодит байдлаас өөр, толгойг нь зөрүүлсэн хөлтэй нь харьцуулахад биеийн доод хэсэг харьцангуй жижиг. Нүүр нь урагш харсан, үсээ толгой дээрээ овоолсон, түүнийг нь будсан, лянхуа суудлаар баруун хөлөө зүүн гуян дээрээ тавьж суусан. Царай гүн бясалгасан байдалтай, зүүн алгаа баруун алганы доор байрлуулж, гэгээрэлд хүрэхийн илэрхийлэл эрхий хуруунуудаа нийлүүлсэн байна (Beer 1996:154). Хөмсөгний дунд цэгтэй, чихний омог урт, хүзүүндээ гурван үрчлээстэй байгаа нь бүгд бие лагшины шинж, бурхад сахиусын чадалтай хүн (хаан г.м.) өлзийт тэмдэг мөн (Fajcsák 2007:196). Тэрээр хуврагын өмсгөл өмсөн нь түүнийг бурхан шиг харагдуулна. Энэхүү улаан өнгөт зураг чимэглэл ихтэй, бодьсдва төрхтэй амгалан дүртэй түүний өөр дүр Аюуш бурханаас илэрхий өөр харагдана. Amitabha/Amitayus Buddha. In: *Himalayan Art Resources*.

Нэр: Цаглашгүй гэрэл, Авид; мон. *Āyāsi ügei gerel, Amidiv-a, Amindev-a, Abida*; тө. *Od dpag med*; скр. *Amitābha*

Гарал: Монгол, XIX зуун

Ерөнхий шинж: 21×15.2×10 см; хүрэл; цутгамал, будаж, алтадсан

Байршил: Угсаатны зүйн музейн Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 55872

Цуглуулсан: Төвдөөс, 1904 оны 12 дугаар сарын 20

Мөн үзэх: moncol.net; collection.neprajz.hu



№ 55872



Amitābha

Amitābha, the Buddha of infinite light and boundless wisdom, is the Dhyāni Buddha of the present era (Joyce 1922:3). This seated representation of him was made of bronze, and the remnants of its original painting and gilding are observable. The proportions somewhat differ from reality, considering that, compared to the head, the crossed legs and the upper body seem to be relatively small. He faces forward toward the viewer, he has the *uṣṇīṣa* on the top of the head marked with painting, the feet are locked in the lotus position, with the right foot over the left thigh. The face mirrors deep meditation, the hands are in the *dhyāna mudrā*, when the left hand is placed under the right with touching thumbs that represents the union of the mind of enlightenment (Beer 1996:154). There is the dot between the eyebrows, long earlobes, the three wrinkles on his neck, that all belong to the *lakṣaṇas* or auspicious signs of *mahāpuruṣas* (Fajcsák 2007:196). His traditional robe of a monk, his Buddha-like representation, and the traces of red painting clearly differentiate him from Amitāyus, his other appearance that would be richly adorned and depicted as a peaceful deity with a Bodhisattva appearance (Amitābha/Amitāyus Buddha. In: *Himalayan Art Resources*).

Name: Khal. *Caḡlaṣḡii gerel, Awid*; Mong. *Āyāsi ügei gerel, Amidiv-a, Amindev-a, Abida*; Tib. *Od dpag med*; Skr. *Amitābha*

Origin: Mongolia, 19th century

Physical features: 21×15.2×10 cm; bronze; cast, painting, gilding

Location: Museum of Ethnography, Hans Leder Collection (Budapest)

Inventory number: 55872

Acquisition: collected in Tibet, 20 December 1904

See also: moncol.net; collection.neprajz.hu

№ 55923



Бурхан багш (Шагжтүв)

Түүхэн Будда Сиддарта Гаутама лянхуа цэцгэн суурин дээр төв төрхтэйгөөр, завилан сууна. Зүүн мутар бясалгах байрлалаар, харин баруун мутраа баруун өвдгийг давуулан газарт хүргэжээ. Энэ байдал нь бодь модны дор гэгээрснийг илэрхийлэх бөгөөд нэг мутраа өмнөө авч нөгөө мутар газар хүрэх мэт байгаа нь арга билэг, хорвоо, нирвааны нэгдлийг илэрхийлнэ. Энэ зурагт Бурхан багш хоосонд бясалган шулмасыг дарсан (Beer 1996:154). Тэрээр мэлхийгээ нээж, урагш харсан, хөх үсээ тэргүүнийхээ орой дээр ердийнхөөрөө овойлгон (ушниша) янзалжээ. Хөмсөгнийх нь хооронд харагдахуйц цэг (уурна), чихний омог урт, мөн бурхан, сахиус бурхадад байх олон онцлог шинжүүд байх ажээ. Зүүн мөрийг даган хуврагийн аливаа гоёл чимэглэлгүй орхимж унжина. Уг дүрслэл сүсэгтнүүдийг ертөнцийн хэргээс ангижруулж, энгийн хүрэхэд туслах юм.

Нэр: Бурхан багш, Шагжтүв, Шагжимаан, Шажимаан; мон. *Burqan baḡsi, Sigemiini*; тө. *Shākya thub pa*; скр. *Śākyamuni*

Гарал: Монгол, XIX, XX зууны зааг

Ерөнхий шинж: 6×10.5×13.5 см; шатаасан шавар, будсан

Байршил: Угсаатны зүйн музейн Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 55923

Цуглуулсан: Төвдөөс, 1904 оны 12 дугаар сарын 20

Мөн үзэх: moncol.net; collection.neprajz.hu

Śākyamuni

Siddhārta Gautama, the historical Buddha is seated in *vajra* posture on a lotus pedestal in his formal appearance. His left hand is in the *mudrā* of meditation, while his right, extended across the right knee, in the earth touching or earth-pressing (*bhūmisparśa*) mudra. The latter symbolizes the Buddha's enlightenment under the bodhi tree, while one hand in the *dhyāna mudrā* and the other in the earth touching mudra together symbolizes the union of method and wisdom, *saṃsāra* and *nirvāṇa*. In this posture Śākyamuni defeated Māra while meditating on emptiness (Beer 1996:154). He gazes forward with opened eyes and his blue hair ends in the usual protrusion (*uṣṇīṣa*) on the top of his head. There is the already scarcely visible dot (*ūrṇa*) between the eyebrows and the long earlobes, characteristics of many buddhas and deities. Across the left shoulder are the outlines of a monk's robe, without any trace of decoration. This representation emits simplicity, which helps devotees detach themselves from worldly matters.

Name: Khal. *Burqan baḡš, Śaḡjitiw, Śaḡjimaan, Śaḡjimaan*; Mong. *Burqan baḡsi, Sigemiini*; Tib. *Shākya thub pa*; Skr. *Śākyamuni*

Origin: Mongolia, turn of the 19th and 20th centuries

Physical features: 6×10.5×13.5 cm; baked clay, painting

Location: Museum of Ethnography, Hans Leder Collection (Budapest)

Inventory number: 55923

Acquisition: collected in Tibet, 20 December 1904

See also: moncol.net; collection.neprajz.hu



№ 55922

Богд Зонхов

Богд Зонховын баримлыг шавраар хийсэн байх бөгөөд сайн хадгалагджээ. Цуглуулганд ирснээс хойш зуу гаруй жил өнгөрсөн хэдий ч будаг нь бараг арилаагүй байх юм. Богд Зонхов бол Төвөдийн бурханы шашны томоохон шинэчлэгч, Гэлүгвагийн урсгалыг үүсгэгч билээ. Тэрээр Төвөдийн зүүн хэсгийн Амдо мужид төрж, бурханы шашны сургаал номлолуудыг эрэлхийлэн олон жил хэрэн явжээ. Тэгсний ачаар төвөдийн бурханы шашны бүхий л уламжлалуудыг судалж, XIV зууны төвөдийн бурханы шашны хамгийн чухал дэг сургуулиудыг нэгтгэсэн Гэлүгвагийн урсгалыг үүсгэжээ (Thurman 2006). Уг шавар баримлаас түүнийг онцлог шинжүүдээр нь төвөггүй таньж болно. Үүнд: шар овоодой малгай, хуврагийн хувцас, мутраа ном айлдах, ном хаялцах байдалтай (ном заах мутарлага) зүрхэн тушаа авсан байна (Beer 1996:153). Мөрөнд нь хоёр лянхуа цэцгийн иш, түүний баруун мутарт оюун билгийн илд, зүүнд нь ном байна. Хөлөө завилж, өнгө алагласан лянхуа цэцгэн дээр заларна.

Нэр: Зонхов, Зунхав; мон. *ᠴᠣᠩᠬᠠᠫᠤ*; тө. *Tsong kha pa*

Гарал: Монгол, XIX, XX зууны зааг

Ерөнхий шинж: 12.5×17 см; шатаасан шавар, будсан

Байршил: Угсаатны зүйн музейн Ханс Ледерийн цуглуулга (Будапешт)

Бүртгэлийн дугаар: 55922

Цуглуулсан: Төвдөөс, 1904 оны 12 дугаар сарын 20

Мөн үзэх: moncol.net; collection.neprajz.hu

Tsongkhapa

